



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот


Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамба хутагтад зориулан хөшөө босгох талаар иргэд, Улсын Их Хурлын зарим гишүүнээс гаргасан саналыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.5.11-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд судлан, холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Ерөнхий сайд /Н.Алтанхуяг/-д чиглэл болгосугай.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээний хэрэгжилтийн талаар 2013 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга /Ч.Сайханбилэг/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ